



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 4/49

Хужирт сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 4 дүгээр баг Шивээт 33 тоот хаягт байрлах “Бизимэн групп” ХХК-ний эзэмшлийн 6211003912 тоот нэгж талбарын дугаартай Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор зориулалттай 10000 м² газрын эзэмших эрхийг, 4 дүгээр баг Шивээт 33 а тоот хаягт байрлах Лэгшидийн Зоригийн эзэмшлийн 6211003913 тоот нэгж талбарын дугаартай Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор зориулалттай 5437 м² газрын эзэмших эрхийг тус тус 40 жилийн хугацаатайгаар сунгаж үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Шинээр газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох, газрын улсын бүртгэлд өөрчлөлт хийхийг Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Т.БАЯРМӨНХ